

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

САНАМЖ

Захиалагч болон үнэлгээний хороо нь ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд захиалагчийн зураг төсөл (техникийн болон ажлын зураг, өртгийн төсөв), ажлын хуваарь, тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулан, уг барилга байгууламжийг ашиглалтад бэлэн болгохтой холбоотой ажил, бараа, үйлчилгээнд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа, үйлчилгээг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.
- Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд санал болгох бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

Зураг төсөл, загвар зураг

Засаг даргын Тамгын газрын барилгын засварын тооцоо

- Барилгын цонхонд гадна талыг сайдингаар амалгаа хийх
- Хананд тэгшилгээ прүсээр хийж шрүфээр тогтооно 1.2 м тутамд
- Цонхны амалгааний дотор талд дулаалгын хөөсөн шахмал хавтан буюу дүйцэхүйц материалаар дулаалж өгнө
- Сайдингийн цонхтой тулах хэсэгт цликон цавуугаар шахаж цавуудна
- Дээврийн усны хаялгыг цэвэрлэх буюу зарим эвдэрсэн хэсгийг засварлаж, буцааж угсарна
- Цонхны хагарсан шилийг сольж 1 өрөөнд одоо байгаатай ижил загварын цонх суулгана
- 1-р давхарын аваарын хаалгыг бүргэд хаалгаар сольж \түүнтэй дүйцэх \ дулаалга цонхны адил хийж өгнө
- 2-р давхарын аваарын хаалгыг авч 1,2*1.2м² вакум цонх суулгана
- Дээврийн тойрсон хүрээ модыг будаж засварлаж, туузан гэрэлтүүлэг хийж өгнө
- Аваарын болон дээвэрт гарах шатыг будна
- Аваарын хаалганы довжоо болон хаяавч бетоны эвдэрсэн хэсгийг нөхөж засварлана.
- Талбайн цэвэрлэгээг бүрэн хийж хүлээлгэн өгнө

Гадна засварын материалын тооцоо

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Гадна сайдинг	М2	512
2	Шрүф\ тэлэгчтэй\	Хайрцаг	10
3	Сайдинг тогтоох шрүф	хайрцаг	10
4	Дулаалгын хөөсөн хавтан	М ³	2
5	Цликон цавуу	ш	50
6	Цонхны хагарсан шил солих 1*0.7м2	м ²	1
7	1 өрөөнд цонх хийлгэх1.7*1.5 м	м ²	1
8	Хаалга 2*1,2м	ш	1
9	2-р давхарын цонх 1.2*1.2м	м ²	1,44
10	Хүрээ мод шат будах будаг \цагаан\	кг	20
11	Цемент	Уут	10
12	хайраг	М3	2

Гүйцэтгэх ажил

№	ажил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Хананд сайдинг угсрах	М2	354
2	Цонх суулгах	ш	1
3	Цонхны шил солих	ш	2
4	Хаалга суулгах	ш	1
5	Хүрээ мод будах	М2	14
6	Усны хаялаг засварлах, цэвэрлэгээ хийх өндөрт	ш	1
7	Шат будах	М2	5

8	Довжоо зарим хэсэгт хаяавч бетон цутгах	M2	10
9	Суулгасан цонхонд амалгаа хийх	ш	2
10	Хаалганд амалгаа хийх	ш	1
11	Цэвэрлэгээ, бусад ажил үйчилгээ		

Нийт засварын ажлын тооцоо: 45,000,000 төгрөг
 \Дөчин таван сая \

